

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244808

“АЛТАН ХҮРДЭН МЯНГАН ХИГЭЭСТ” ХОЖМЫН ТҮҮХЭН
СУРВАЛЖУУДАД ХЭРХЭН НӨЛӨӨЛСӨН НЬ

Л.Халиун

Түлхүүр үг: Алтан хүрдэн мянган хигээст, сурвалж, хэл, түүх

Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хигээст”-ийг бичихдээ ашигласан судар шастирын нэрийг тусгайлан тоочсонгүй зөвхөн зохиолынхоо дотор “Асрагч нэртийн түүх”, “Да Юань улсын бичиг” гэсэн хоёр сурвалжийг л дурдсан байдаг бөгөөд хятад, монгол, төвөд олон зүйл судар шастир түүхээс ашигласан нь тодорхой байдаг. Тухайлбал, түүхэн үйл явдал, нэр, он цагийг нягтлахын хамт тайлбар зүүлт оруулан “зарим бичигт”, “олонх бичигт” гэх мэтээр олон удаа тэмдэглэн зөрөөтэй мэдээг эхэд харгуулан заажээ. Тайлбар зүүлтийг тодолж буй үг, өгүүлбэрийнхээ хойно жижиг үсгээр мөр дагуулан бичиж оруулсан нь зохиолоос илэрхий харагддаг. Ийнхүү жижиг үсгээр мөр дагуулан бичих арга монголын түүх бичлэгт XVII-XVIII зууны үеэс нэвтэрсэн гэж үзэж болно. Үүний бас нэг жишээ нь Гомбожавын “Гангын урсгал”-д тус аргыг хэрэглэсэн байна.

XVII-XVIII зууны ихэнх зохиол бүтээл нэг нэгнээсээ хуулбарласан юм уу дам эшилсэн зүйл их байдаг ч Энэтхэг, Төвөдийн хаадын түүхийг өгүүлээд дараагаар нь Монголын хаадын түүхийг бичдэг нэгэн онцлог хадгалагдсаар ирсэн.

Бидний судлан буй сурвалжийн тухайд нэг нь нөгөөг нөхсөн зүйл цөөнгүй боловч тодлоход бэрхтэй зүйл ч байдаг. Тухайлбал, үг үсэг, хэл найруулга, агуулга өгүүлэмж таарах тал байхад таарахгүй тал ч бий. Хэрэглэгдэхүүний тухайд энэ сурвалжийг ашиглажээ хэмээн үзэхэд ашиглаагүй байдаг. Тиймээс зарим хэсгийг цухас тэмдэглэсэн нь ажиглагддаг.

“Алтан хүрдэн мянган хигээст” түүхэн сурвалж болохын хувьд монгол аймгуудын гарлын тухай; Монголын эзэнт гүрний үеийн феодалын цол хэргэмийн тухай, Лигдэн хутагт хааны дэргэд байсан төрийн тушаалтан нарын тухай сонирхолтой мэдээнүүд их бий. Тиймээс үүнийг монголын түүхийн судалгааны үнэт хэрэглэгдэхүүн гэж эрдэмтэд үздэг.

“Алтан хүрдэн мянган хигээст”-д нэр нь үл мэдэгдэх монгол, төвөд түүхэн сурвалжуудын тухай, тэдгээрийг хэрхэн яаж, ямар байдлаар ашигласныг тодлох зайлшгүй шаардлагатай байна. Үүний тулд В.Хайссиг(1959) -ийн Копенгагенд

sadun toyin blam-a ngags dbang bsdan bas rgya mtshan-u gegen qubiluysan bui:...” хэмээжээ.

Мөн “Алтан товч” нь “Алтан хүрдэн мянган хигээст” бичгийн 5 дэвтрийн зарим хэсгийг тэр хэвээр нь авсан байдаг.

Рашпунцагийн “Болор эрх”-д “Алтан хүрдэн мянган хигээст” хэрхэн нөлөөлсөн тухай

Рашпунцаг бол Чингис хааны алтан ураг, Батмөнх Даян хааны тавдугаар хөвгүүн Алчуболдын есдүгээр үеийн ач бөгөөд тэрээр Бээжинд олон жил сууж байсан нь түүнийг монгол, манж, хятад, төвөд хэлийг эзэмшин олон хэлний судар бичгүүдтэй танилцахад дөхөм болж байсан биз ээ. Рашпунцаг нь “Дай Юань улсын Болор эрх” хэмээх эл зохиолоо Тэнгэрийн тэтгэсний 39 дүгээр он(1774)-д эхлэн Тэнгэрийн тэтгэсний 40 дүгээр он(1775)-ы хооронд бичжээ. Зохиолоо бичихдээ шүүмжлэх чиглэлийг гол болгосон бөгөөд ашигласан зохиолуудын дотор Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” чухал хэрэглэгдэхүүн болжээ. Тухайлбал: Дарма гүүшийн өөрийнх нь зохиосон “Алтан хүрдэн мянган хигээст” лавтай байсан бөгөөд ном судруудыг нягтлан үзэх явцад хуулбар эхийг нь олж үзсэн бололтой. Тиймээс хуулбарлан бичигчийг нэрийг заалгүй бичжээ.

“Болор эрх” (2006) -ийн 17 дугаар талд: “... Бурхан нирваан дүр үзүүлснээс нэг мянга илүү жил болсны хойно, Энэтхэгийн Шагъяа-гийн язгуур Зуун цэрэгт хэмээх Шарва нэрт хааны таван хөвгүүн бүхүйгээс отгон нь үс хумс нь хөхөвтөр хар, хөл нь шувуу мэт сарьстай, нүдээ шувуу мэт дээш анигч, лавай мэт шүдтэй хөвгүүн төржээ. Төлгөчин бэлгэчнээр үзүүлж муу ёртой хэмээсэнд, тэр хөвгүүнийг зэс хуурцагт хийж, Ганга мөрөнд огоорвой...” гэжээ.

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”(2012) -ийн I 9r 10- I 9v 02 “...tegünčilen iregsen-luy-a[=-lüge] sačuyu: nasutu saraba[=shar ba] qayan-u öčüken köbegün: quruyun inu toor-iyar barilduysan: keris kömüsgetü nidün-iyen degegsi aniγči: labai sidütü böküyin[=bökü-yin] tula: belgečin iručin: sinjilejü ese medeged: jarim yosun-a tngri čidkürün qubilyan bayinam kemegsen qayurčiy-dur kijü yangγ-a mören-e oγurabai[=oγurbai]:...” гэжээ

“Болор эрх”-ийн 27, 28 дугаар талд: “... тэнгэр суут богд газрын Эсэрва дээд төрөлхт бээр ялж төгс нөгчсөн бурхан мэндэлснээс хоёр мянган нэгэн зуун наян есдүгээр элдэв хэмээх усан морин жилийн зуны тэргүүн сарын тэргэл өдрөө, Онон мөрөн дэх Дэлүүн Болдага нэрт газраа, Өгэлүн хатнаас мэндэлсэн...” гэжээ.

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-ийн II 2r 12- II 2v 09 “... ša ki-a[=šakiy-a] arslan doysin kemekü temür bečin jilün zaidar-a[=zedra] sayin sineyin[=sin-e-yin] dolun-a[=doluγan-u] büs[=bus] odun-u edür-e: sowde dowani[=suddhodana] qayan: maqa may-a qoyar-un köbegün bolun lumbini[=lümbüni]-yin oi-dur: eke-yin barayun suγun-ača mendülegsen-eče inayši: qoyar mingγan nigen jayun qorin γurban jil-e boluysan-dur: olan-a ergügdegsen qayan-u altan uruy buyu: burum modutu-yin uy ša ki-a [=-šakiy-a] čidayči-yin uy ijayur-i tngri-yin ündüsü-tü borjiged obuytu[=obuytu] keyid yasutai: keyid yasuyi

čayan yasun kememü: altan yasu buyu: yisükei batur[=bayatur]-un aqamad köbegün činggis kemekü bolun: činggis öber-iyen qormusta tngri-yin köbegün kemegsen bayinam: yayun bolbaču kitad töbed mongyol olangkin šasdir bičig-dür[=-tür]: tngri-yin köbegün kemen ögüleged: qotala-da tngri-yin köbegün-e yekede aldarsibai: eldeb kemekü er-e usun morin jildür tngri-yin köbegün boyda ene törübei:...” гэжээ.

Эндээс харвал, Богд эзний мэндэлсэн оны зөрүүтэй хэсгийг Рашпунцаг харьцуулан үзээд, Жанжаа Лалида Базар буюу Ролбийдоржийн зохиосон “Зандан зуу”-гийн долоон эрдэнэ эрих”-ийг гол болгоод, Бурхан багшийн мэндэлсэн жилийг модон бараас эхлэн тоолж, богд Чингис хаан мэндэлсэн усан морин жил бээр хоёр мянган нэг зуун наян есдүгээрт болмуй хэмээгээд даган бичсэнээ тэмдэглэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, зарим нэгэн мадагтай зүйлийг бусад сурвалж бичгүүдэд хэрхэн бичсэнийг үндэслэн тухай бүр өөрийн дүгнэлтээ өгч бичжээ.

“Болор эрих”-ийн 51 дүгээр талд: “...тэр үдэш Бэчин нэрт хөтчөө Боорчийг тэнсүүлэхээр зарсанд, Бэчин Боорчийн гэрийн гадна эчиж чагнаваас, Боорчийн Төгөлдөр гоо нэрт гэргий нь өгүүлрүүн: “Бүтэхийн урьд учирч Бүгд улсыг хураалцлаа. Бүрэн их төрийг нь хашиж Бүгдээс илүү хүчийг өгсөн бөгөөтөл энэ мэт их хишигт эс хүртвэй” хэмээсэнд Боорчи өгүүлрүүн: “Ер эм хүний жолоо богино, санаа нь цухал эзний алтан оосор бат болохул надад олз, эр чинь би амьд бөгөөс чамд олз”...” (2006:) гэжээ.

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-ийн II 7v 03-II 7v 10. “...köteči[=kötüči] boyul mečin-i jaruḡu borji[=boyurji]-yin ger-i čingnayulbasu: tegüsgen ḡuw-a neretü gergei inü ögülerün: bütükü-yin urida učaraḡu: bükü ulus-i quriyalčiyad: būrin yeke törü-yi inü qasīḡu: böḡüde-eče ilegüü küčün öḡbei či:...; ...kemen kelegsen-dür borji[=boyurji] ögülerün: yerü em-e kümün-ü jiluy-a boyunai[=boyuni]: sanay-a čiqul: ejen-ü altan oosar[=oḡusar] böke bolqula nadur olḡa: bi amidu bolqula: čimadur[=čim-a-dur] olḡa bisüü:...” гэжээ.

“Болор эрих”-ийн 522 дугаар талд: “... Шуньди хаан улс төрөө алдсаны тул гэмшиж дуулруун:

Хаан Чингис эзний зохиосон улс минь!
 Гайхамшигт Сэцэн хааны засаг тогтоосон төр минь!
 Хамаг улсын шүтээн тулга болсон Дайду минь!
 Харгүй өгүүлсэн Лаха Ибаху хоёрын үгийг эс авсан хор минь!
 Эрдэнэсээр хээлсэн бат бөх Дайду минь!
 Эртний хаадын зуслан Шанду шар тал минь!
 Элдвээр бүтсэн найман талт цагаан суварга олон шүтээн минь!
 Эн олон дөчин есөн түмэн их Монгол улс минь!
 Хутагтан бурхдын байгуулсан наран мэт шашнаа
 Хубилай хааны тогтоосон хоёр ёсоо
 Хорт Чжу Хун У, Буха хоёрын гарт алдаад
 Гутамшиг муу нэр Ухаант хаан надад хоцорвой
 Хаан эцэг өвгийн тогтоосон улсаа
 Хамгаас эрхлэн байгуулсан төр шашнаа
 Харт Хятадын гарт сэрэлгүй алдаад

Хамаг муу нэр Ухаант хаан надад буувай.
 Тэнгэрлэг эцэг Чингис хааны алтан ургийн ёсыг
 Дээд бурхан хувилгаан Сэцэн хааны алтан харшийг
 Дэлхий дахины хаан агсан Ухаант хаан би бээр
 Тэнгэрийн заяагаар алдвай, төр шашнаа
 Хаан эцэг суут богдын хасбуу тамгыг
 Хамгаас хайрлан гаргавай, Ухаант хаан би.
 Хатгалдаж гарвай Бухатөмөр чэнсян бээр
 Хас их төр алтан урагтнаа өнөд тогттугай!
 Түмэн үед хамаг төр шашны тулд гомдож дууллаа...” хэмээснийг

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-ийн III 10r 12- III 11r 07 дугаар талд:
 “... uqayantu qayan dayidu qotan-dur yeke törü-ben aldayad gemsijü ögülerün: qayan
 činggis ejen-ü jöban[=joban] jögegsen yeke ulus minu: qamuy ulus-un sitügen tulay-a
 tüsige boluysan dayidu qota minu: qara[=qar] ügei ögülegsen lanay ibaqu qoyar-un
 üge-dür ese oruysan qoora[=qoor-a] minu: erdenis-iyer kekelegsen[=kelkigsen] beki
 böke dayidu-dur ebüljigsen jiryal minu: engke amur-iyar jiryan jusuysan: šangdu
 qayibung šira[=šir-a] tala[=tal-a] minu: eldeb jüil-iyer бүтүгсэн naiman taltu čayan
 subury-a olan sitügen minu: ay-a olan döčin түмен yeke yool mongyol minu: qutuγ-
 tan burqad-un bayiyuluysan: naran metü šišin[=šasin]-iyan: qubilai sečen qayan-u
 toytaγaysan qoyar sayiqan yosun-iyar qoortu jüüge buq-a qoyar-un γar-dur[=-tur]
 aldayad: yutumsiγ mayu ner-e-yi uqayantu qayan nadur talbibai: qayan ečige ebüge-
 yin toytaγaysan: olan jüil olja-iyar: qamuy-iyar erkilen toytaγaysan törü šišin[=šasin]-
 iyan: qartu kitad ulus-un γar-dur[=-tur] serel ügei aldayad: γayčakü šundi qayan nadur
 qamuy mayu ner-e bayubai: tenggerlig ečige činggis qayan-u altan uruy-un yosun-i
 degedü burqan-u qubilγan sečen qayan-u altan qarsi-yi delkin[=delekei] dakin-u ejen
 bölüge: šundi sečen bi: tngri-yin jiyay-a-bar aldabai törü šišin[=šasin]-i qayan ečige
 sutu boyda-yin qasbau[=qasbuu] tamaγ-a-yi qamuy ulus-ača qayirlan[=qayiralan] abču
 γarabai[=γarbai]: uqayantu qayan bi qadqulduju tuslan γaryabai: buq-a temür čingsang
 qas yeke törü altan uruy-tan[=uruytan]-dur önide toytatuγai: түмен üy-e-dür gegen
 uqayantan-u delgeregölүгсэн naran metü šišin[=šasin] nom gilbalun[=gilbayulun]
 qočurabai: qartu jüüge buq-a qoyar-un γar-dur[=-tur] genedejü aldabai: toγan temür
 qayan bi kitad ulus-dur[=-tur] geyigölүн iretügei: ejen-ü altan uruy-tan mongyol ulus-
 dur kemen: šundi qayan šišin[=šasin] törü-dayan[=-degen] yomuduju ögüleged: ergijü
 toytaγaqu-yi iregebei[=irügebei]:...”

Ната Гомбованжилын “Алтан эрих”-д “Алтан хүрдэн мянган хигээст” хэрхэн нөлөөлсөн тухай

“Алтан эрих” (2006) буюу “Монгол орноо шашин төр тогтсон ёсыг сайтар өгүүлсэн тунгалаг ухаант залуусын хоолойн чимэг тунамал гэрэлт алтан эрих” хэмээхийг Зүүн авга нарын хошууны бэйс Гомбонамжил 1817 онд зохиожээ.

Ната Гомбованжилын “Алтан эрих”-эд: “...[38r]... Түүнээс Лигдан хутагт хааны Нян Нян [38v] тайху, Су тайху хоёр хатан, Эжэй хонгор, Авай хоёр нялх хан хөвгүүнтэй, нөхөр Цахар цэрэг хоёр гурван мянгаас илүүгүй, эд таваараа

бараад зовниж, алтан Гүр Махагалын бие, Пагва ламын амилсан нэгнийг залж явсан, түүнээ дэрний тэргүүнээ залаад, агуу их тахил бэлдэн тахиж, “Бид хоёр бэлбэсэн хоёр нялхтай, нэгэн их хүнийг шүтэлгүй үл болмуй. Аль зүгт хэнийг шүтэхийг тэр зүг нүүр хандах болтугай!” хэмээн залбираад, нойрсож өглөө үзвээс, шүтээний нүүр дорно өмнө зүг хандаж байх ба урьдаас Манж эзэн богдын алдрыг сонссон лугаа [39r] нийлж, Мүгдэнд эчээд, Сэцэн хааны аравдугаар онд эрдэнийн юндүн тамгаа өргөж дагавай. Дээрээс их л ачтайяа хайрлан, хоёр хатныг биедээ хатан болгон авбай. Бага хатнаас төрсөн Тусанган Чин ваныг мэндэлбэй. Эжэй Хонгорт гүрний гүнжийг өгөв...” гэжээ.

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”(2012) -ийн Гуравдугаар бүлгийн 26b талд: “... lingdan[=liydan] qutu-yin:dlegdle tayiqu: sūtai tayiqu: yeke bay-a qoyar qatun: ezi[=ejei] qongyur: abanai: qoyar k'injin köbegün-ber: čaqar ulus sarnin tarqaju: ülegsен yurbayad mingyan ulus-tai gedürgü ergijü: sedkil anu masi sengseren yuniraju: ali жүг-i түsibesü amurjiqu bolbau kemen: .pagsba[='phags ba] blam-a-yin qayiralaysan 'gür[='gürü] maqak'ala-yin emüne[=emün-e]: takil-i ergüged: ali жүг qandubasu tere жүг dayay-a kemen jalbariju: qonuysan-u manayar örlüge jegün жүг qanduju бүкүi-dür бүгүdeger yeke bayasun: yayiqamsiy yeke tayizung öndür boyda-yin aldar-i sonuysan bile: tere жүг-čü neyilemü kemen: mügden qotayi[=qota-yi] jorin yabuju kürüged: boyda qayan-du qasbu[=qasbuu] tamayaban[=tamay-a-ban] ergüged dayaju oruysan-dur: boyda qayan yeke örsiyeen qayiralaju: qoyar qatun-i qarsi-dur-iyen abubai: bay-a qatun-ača түženg da čing wang yaruysan bui: ejei qongyur-tu ulus-un abaqai gürnei[='gürün-ü] güngjü qayiralaju: čing wang talbibai:...”

Ишбалданы “Эрдэнийн эрих”-д “алтан хүрдэн мянган хигээст” хэрхэн нөлөөлсөн тухай

“Эрдэнийн эрих”(2006) буюу “Монголын оронд хааны угсаа хийгээд шашин дэлгэрсэн, шашныг баригчин үсэг урласан, хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсны ёсыг номлосон эрдэнийн эрих оршвой” хэмээх сурвалжийг Ордосын тойн ханчэн бандид гэлэн Ишбалдан арван дөрөвдүгээр жарны модон хонин жил буюу 1835 онд зохиожээ.

Ишбалданы “Эрдэнийн эрих”-эд: “...[2r]... tamčayan ba qorča mergen kiged, egüni[=egün-i] köke debter-tü: lobun badmajungnai-yin qubilyan mön: edüge-čü mangyus-un aman-i daruju jokiyaba: kemen nomlaysan...” гэжээ.

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-ийн I 11r 04- I 11r 05 дугаар талд: “... tamačin: qoričil mergen: qoričal mergen-i badma sambau-a[=pad ma ,byung gnas] yeke bayši mön kemekü anu[-inü] bui: tabun уүчим buyural: qali jiryuyan yaljiyuu:

Ишбалданы “Эрдэнийн эрих”-эд: “... [2v]... qangjin: layijingdorji -yin teüke-dür usun-u ündüsü ayulan-dur tulaqu: kümün-ü ündüsü tngri-dür tulaqu kemen nomlaysan anu: čuqum ünün kü ilerkei bolai:...” гэжээ.

“Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-ийн I 12r 04- I 12r 05-талд: “... mongyol-un qad-un ündüsün tngri-yin ündüsütü bolbai: ene inü kümün-ü udum eki tngri-eče irekü kemegsen-lüge udq-a jokildumui: ...” гэжээ.

Алтан хүрдэн мянган хигээст дараа үеийнхээ монгол түүхэн сурважуудад хэрхэн нөлөөлснийг авч үзэхэд ийм байна.

Дашрамд дурдахад Японы Моригава Тацүо Дарма гүүш сурвалжаа бичихдээ Сүмбэ хамба Ишбалжирын төвөд хэлээр зохиосон “Энэтхэг, хятад төвөд, монголд дээд ном ямар мэт дэлгэрсэн ёсны Галбарвасан модон хэмээх оршвой” сурвалжийг ашигласан хэмээсэн нь цаг хугацааны хувьд тохирохгүй юм. Учир нь Сүмбэ хамба уг зохиолоо XIII жарны шороон луу жил буюу 1748 онд бичсэнээ төгсгөлийн үгэнд тодорхой тэмдэглэсэн буй. Тиймээс тус зохиолыг Дарма гүүш ашигласан гэх үндэслэлгүй бөгөөд Дарма гүүшийн гарт чухам ямар түүхэн сурвалж байсан бэ гэдэг асуулт гарч ирж байна. Бидний үзэхээр, Гоо лозава Шонубалын 1476-1478 оны хооронд зохиосон “Хөх дэвтэр”-ийг ашигласан байх магадлалтай. Учир нь зохиогч Жамбын “Асрагч нэртийн түүх”-ийг голлон ашигласан учраас Хөх дэвтэр сурвалжийг дам ашигласан байх бололцоотой юм.

Харин хятад сурвалжийн хувьд “Юань Ши”-аас хаадын оны цол болон алтан ургийн нэрс, цол хэргэм, газар орны нэр, зарим үйл явдал зэргийг ашигласан байдаг. Тухайлбал:

- Есүхэй баатарт нэхэж өргөсөн цол нь 烈祖神元皇帝
- Чингис хааныг “太祖法天启运圣武皇帝” буюу “Тэнгэрийн бошгоор улирлыг нээсэн богд хаан” хэмээн нэхэн өргөмжилсөн
- Өгөөдэй хааныг 太宗英文皇帝
- Мөнх хааныг 宪宗桓肃皇帝 буюу “Асрал өглөгч гэгээн элбэрэлт хуанди”
- Гүюг хааныг 定宗简平皇帝 гэж хааны цол нь Зэн зүн, нэхэмжлэн өргөмжилсөн нь Жянь бы хуанди юм.
- Хубилай хааны 世祖圣德神功文武皇帝 буюу “Дээд эрдэмт гайхамшиг алдарт сүр жавхлант хуанди сэцэн хаан”, “шизү” хэмээсэн нь хааны цол бөгөөд олонх сурвалж бичгүүдэд “Сэцэн хаан” хэмээн тэмдэглэсэн байдаг.
- Хубилай хааны хүүхдийн тухай дараах мэт байнам. Энэ нь “Юань ши”-гийн 2724 дүгээр талд “世祖皇帝，十子：长朶而只王；次二皇太子真金也；次三安西王忙哥刺；次四北安王那木罕，无後；次五雲南王忽哥赤；次六爱牙赤大王；次七西平王奥鲁赤；次八寧王闊闊出；次九镇南王脫歡；次十忽都鲁帖木兒王。” гэжээ. Үүнийг орчуулбал, “Шизү хаанд, Дорж ван, хуантайцзы Жингис, Аньши ван Мангала, Бэй ань ван Намухан/үр үгүй/ Юннань ван Хөхэчи, Аяачи да ван, Шипин юань Олооч, Нинван хөхөчү, жан нант ван Тао күн, хотулу төмөр” болох бөгөөд “АХМХ”-ийн “III6v12 kitad bičig-tür quwang tayizi jin gin[=jingin], ani si wang mangk‘ala, binani wang nomuqan, yuwan nan wang güng‘rzal, III 7r 01 kitad bičig-tür quwang tayizi jin gin[=jingin], ani si wang mangk‘ala, binani wang nomuqan, yuwan nan wang güng‘rzal, ayaži tayiji, si ping wang ayuluyči, ing yuwan gün[=güng] wang güngjü, jan an wang toyan,

qulad temür tayiji arban köbegün kemejüki” гэжээ.

Ийнхүү хятад сурвалжид хаадын цолыг тэмдэглэсэн байдал нь тухайн үеийн хятад хэлний дуудлага ямар байсантай шууд холбогдох бөгөөд эдүгээ буруу уншиж ойлгох явдал цөөнгүй гардаг байна.

- Төмөр хааны цолыг чэн чүн 成宗, нэхэж өргөмжилсөн цол нь 钦明广孝皇帝 буюу “Тэгээн сүсэгт уудам ачлалт хуанды”, монголоор цолыг “Өлзийт хаан” гэдэг.
- Аюурбарбад хааны цолыг 仁宗, нэхэж өргөмжилсөн нь 圣文钦孝皇帝 буюу “Хичээнгүй элбэрэлт үлэмж өршөөнгүй гайхамшиг богд хаан” буюу “Буянт хаан”
- Содбал гэгээн хааны цолыг 英宗 гэж, нэхэж өргөмжилснийг 睿圣文孝皇帝 буюу “Тэгээн богд гүн элбэрэлт хуанди” гэжээ. Монголоор “Тэгээн хаан”.
- Есөнтөмөр хааны оны цолыг 泰定 гэдэг.
- Хошил хаан буюу Хүсэлэ хааны цолыг 明宗 гэж, нэхэж өргөмжилсөн цолыг 翼献景孝皇帝 буюу “Тэгээн төгөлдөр их элбэрэлт хуанди” гэжээ. Монголын түүхэнд “Хутагт хаан” гэдэг.
- Ринчинбал хааныг 宁宗 зэргээр тэмдэглэсэн байна.

Энэ нь хожмын түүхэн сурвалжуудад монгол, хятад нэрийг зөв оноон нэрлэхэд ихээхэн түлхэц болсон төдийгүй лавлах материалын шинжтэй болсон гэж үзэж болно.

Дүгнэлт

Аливаа ард түмэн түүхийг үнэн бодит байдлаас сэдэвлэн, өмнө үеийн түүхийн бүтээл туурвилд шүтэж, үе үеийн эрдэмтэн мэргэд түүхийг зүйл зүйлээр бичиж ирсэн. Анхны түүхэн зохиол нь аман яриагаар дамжиж олон хувилбараар бичигт тэмдэглэгдэн үлддэг. Монголчууд лавтай, XIII зуунаас хойш түүх шастираа бичгээр туурвиж, хойч үеийн түүхч нь өмнөх үеийн түүхэн зохиолыг залгаж бичиж ирсэн баялаг уламжлалтай. Үүний нэг нь Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” юм. Мөн Монголын түүхийн гол тулгуур бүтээлийн нэг гэж Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээс” бичгийг үзэж болох бөгөөд 1739 оноос хойш гарсан сурвалж бичгүүд ихээхэн ашигласан байна хэмээн үзэж байна.

Ном зүй

Монгол бичгээр:

Altan kürdün mingyan gegesütü bičig des Dharma (1739), Die Familien- und Kirchengeschichtsschreibung der Mongolen, Teil I: 1618. Jahrhundert von Walther Heissig, Otto Harrassowitz· Wiesbaden, 1959.

Gombuřab. (1981). Gangyayin urusqal, Čoyiji tulıan qaričayulju tayilburilaba, Öbür mongyolun aradun keblelün qoriya.

Altanša Na. (1993). Mongyolčud-un öčügedür-ün mör I, II, Öbür mongyolun surıam kümüjil-ün keblelün qoriya.

Buyanbayatur. (2007). Quriyangyui altan tobči-yin eke bičig-ün sudulul, Öbür mongyolun aradun keblelün qoriya.

Dai yuwan ulus-un bičig. (1987). [min] Süng liyan nar jokiyaba, [čing]Tüdeng, Öljeyitü, Sereng, Sonum orčiyulba, Öbür mongyol-un soyul-un keblel-ün qoriya-a.

Danjuur. ĵiran ĵiryuduyar boti, modun barun mongyol keblel.

- Dharma. Altan kürdün mingyan kegesütü, Čoyiji tulıan qarıçayulju tayılburılaba, Öbür mongyol-un aradun keblel-ün qoriy-a keblegülbe, Köke qota, 1987.
- Walther Heissig. “Altan kürdün mingyan kegesütü bičig eine mongolische chronik von Siregetü guosi Dharma(1739)”. Monumenta linguarum Asia maioris. Band I: Kopenhagen, 1958. 125pp.
- Jang mu. (1988). Mongyolun qosıyü nutuyun temdeglel, Namyun Banzirayča mongyolčilaba, Ündüsütenü keblelün qoriya.
- Ulayančimeg.(2005). XVII-XIX jayun-u üy-yin mongyol teüken surbulji bičig-üd-ün qarıçayuluysan sudulul, mongyol tulıur bičig-ün sudulul, begejing.
- Čing ulusun üyeyin mongyol qosıyü čiyulıan. (1984). Namsarai nayirayulba, Öbür mongyolun bayačudun keblelün qoriya.
- Rasipungsuy. (1985). Bolur erike, KokeÖndür qaryuyulun tulıaba, Öbür mongyolun aradun keblelün qoriya,
- Čing ulus-un üy-e-yin mongyol qosıyü čiyulıan. (1984). Namsarai nayirayulba, Öbür mongyolun bayačud keüked-ün keblelün qoriya.

Монгол хэлээр:

- Асрагч нэрт(-ийн) түүх (Эх бичгийн судалгаа), (2002). Галиглаж үгийн хэлхээг үйлдэн хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдарсүрэн, И Сөн Гю, MONUMENTA MONGOLICA: tomus I, Улаанбаатар.
- Бүрнээ Д. Энхтөр Д. (2001). Төвд-Монгол толь бичиг, Улаанбаатар.
- Гэрэлбадрах Ж. (1999). XV-XVII зууны Монголын ноёд язгууртны зэрэг дэвийн асуудалд, Улаанбаатар.
- Ишбалдан. (2006). Эрдэнийн эрих, Төвд хэлээрх сурвалжуудтай харгуулан, монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хэлхээс хийсэн Д.Бүрнээ. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, боть 19, МУИС, МСТ, МХСС, Эх бичиг-Алтай судлалын тэнхим, Улаанбаатар.
- Мэргэн гэгээн Лувсамдамбийжалцан. (2006). Алтан товч, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, боть 12, МУИС, МСТ, МХСС, Эх бичиг-Алтай судлалын тэнхим, Улаанбаатар.
- Ната Гомбованжил. (2006). Алтан эрих, Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн доктор(Ph.D), проф. Д.Бүрнээ. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, боть 17, МУИС, МСТ, МХСС, Эх бичиг-Алтай судлалын тэнхим, Улаанбаатар.
- Рашпунцаг. (2006). Болор эрих, Монгол бичгээс хөрвүүлж тайлбар хийсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн нар. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, боть 13, 14, МУИС, МСТ, МХСС, Эх бичиг-Алтай судлалын тэнхим, Улаанбаатар.
- Халиун Л. (2012). “Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” /1739/ хэмээх Монгол түүхэн сурвалжийн харьцуулсан судалгаа”, БНХАУ. ӨМИС. Монгол судлалын дээд сургууль.

Хятад хэлээр:

- 蒙古回部王公表傳（第一輯）. (1998). 包文漢、奇·朝克圖整理，內蒙古大學出版社.
- W. 海西希. (1987) 论（金轮千辐），蒙古学资料与情报（季刊）. 第三期.
- 乔吉. (1994). 蒙文历史文献概述， 內蒙古人民出版社，呼和浩特.

Abstract

Every nation is based on true facts and the revered historical creations of previous generations. Scholars of various eras have written history in different ways. The first historical works were passed down orally and various written versions emerged. The Mongols have certainly had a tradition of writing their history since the 13th century, with historians in later generations continuing the work of their predecessors.

One such work is Dharma güüş's Golden Wheel of a Thousand Spokes. This work is considered one of the main foundational texts of Mongolian history and it is noted that sources dating from 1739 onwards have been significantly utilised.